



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/104

Мандалговь

Түшигмандал ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2019 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн А/42 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Хот тохижуулах ОНӨААТҮГазрын албан хэрэгцээнд автомашин”-ыг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Түшигмандал” ХХК-ийг сонгон 44,000,000 (дөчин дөрвөн сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Техникийн үзүүлэлтийн дагуу автомашиныг хүлээлгэж өгөхийг “Түшигмандал” ХХК-ний захирал (С.Дарьбазар)-т үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хот тохижуулах ОНӨААТҮГазрын дарга (Р.Энхмаа) нарт тус тус үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488190294